


# ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС – PMI (2025 оны III улирлын түүвэр судалгааны тайлан)

## 1. Худалдан авалтын менежерийн индекс (PMI)

**Ерөнхий индекс:** Монгол Улсын худалдан авалтын менежерийн ерөнхий индексийн утга 2025 оны III улиралд өмнөх улирлын утгатай ойролцоо түвшинд буюу **45.4<sup>1</sup>** гарлаа. Улмаар, тус индекс сүүлийн 3 улирал дараалан агших мужид хэвээр хадгалагдаад байна (Зураг 1).

**Зураг 1. Ерөнхий индекс**


PMI, 50=өөрчлөлтгүй



**Нийлмэл индекс:** Бараа материалын нөөцийн индекс 1 улирлын дараа эргэн агших мужид шилжиж буурсан бол үйлдвэрлэл, шинэ захиалгын индексийн утга тус тус сүүлийн 3 улирал дараалан агших мужид гарлаа. Харин ажил эрхлэлт, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индекс тэлэлтийн мужид шилжиж сайжраад байна (Зураг 2).

**Зураг 2. Нийлмэл индекс**


PMI, 50=өөрчлөлтгүй



<sup>1</sup> PMI нэгдсэн индексийг тооцоходоо судалгаанд хамрагдсан нийт аж ахуйн нэгжүүдийг ажилчдын тооны бүлгээр бус борлуулалтын орлогын бүлгээр ангилж, жингийн харьцааг тооцоход өөрчлөлт оруулснаар индексийн түүхэн цуваанд засвар оруулсан болно.


**Салбарын индекс:** 2025 оны III улиралд барилгын салбар судалгаа эхэлснээс хойш 19 улирал, дотоод худалдааны салбар сүүлийн 4, аж үйлдвэр, үйлчилгээний салбарын үзүүлэлтүүд тус бүр 3 улирал дараалан агших мужид гарлаа. Өмнөх улирлын утгатай харьцуулахад барилгын салбар 5.6, аж үйлдвэрийн салбар 3.1, дотоод худалдааны салбар 2.0 нэгжээр тус тус буурсан бол үйлчилгээний салбарын үзүүлэлт 6.4 нэгжээр өсөөд байна (Зураг 3).

**Зураг 3. Ерөнхий индекс, салбараар**



Үйлдвэрлэлийн индексийн утгыг эдийн засгийн өсөлттэй (бодит ДНБ-ий жилийн өөрчлөлт) харьцуулахад үйлдвэрлэлийн индексийн утга 50-аас их гарсан дийлэнх үеүдэд эдийн засаг өсөлттэй гарчээ. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн индексийн утга нь бодит ДНБ-ий өсөлтийг тайлбарлах чадвар өндөр байна (Зураг 4).

**Зураг 4. Бодит ДНБ-ий улирлын өөрчлөлт болон үйлдвэрлэлийн индекс**



## 2. Салбарын үзүүлэлтүүд

**Аж үйлдвэр:** 2025 оны III улиралд салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд ажил эрхлэлтийн үзүүлэлт тэлэлтийн мужид гарсан бол бусад үзүүлэлтүүд агших мужид гарлаа. Өмнөх улирлын утгатай харьцуулахад нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 4.4 нэгжээр өссөн (*хугацаа богиноссон*) бол бараа материалын нөөц 13.4, ажил эрхлэлт 5.1, үйлдвэрлэл 4.1, шинэ захиалга 1.2 нэгжээр тус тус буурлаа (Хүснэгт 1).

**Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр**

| Үзүүлэлт                          | 2021 |      |      |      | 2022 |      |      |      | 2023 |      |      |      | 2024 |      |      |      | 2025 |      |      | Өөрчлөлт | Улирлын өөрчлөлт |
|-----------------------------------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|----------|------------------|
|                                   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  |          |                  |
| Аж үйлдвэр ерөнхий индекс         | 40.2 | 44.2 | 46.2 | 44.5 | 35.6 | 45.9 | 46.9 | 53.1 | 50.2 | 52.6 | 54.1 | 59.3 | 55.2 | 49.9 | 48.9 | 54.2 | 45.6 | 49.7 | 46.6 |          |                  |
| Шинэ захиалга                     | 36.3 | 44.9 | 50.0 | 55.3 | 36.3 | 44.5 | 53.3 | 54.3 | 47.9 | 55.3 | 58.0 | 61.4 | 54.5 | 46.1 | 46.5 | 49.8 | 39.8 | 45.3 | 44.0 |          |                  |
| Үйлдвэрлэл                        | 34.3 | 45.0 | 44.5 | 41.9 | 35.4 | 45.4 | 47.9 | 61.5 | 50.3 | 57.8 | 56.7 | 65.4 | 54.3 | 59.3 | 54.1 | 57.1 | 44.4 | 49.0 | 45.0 |          |                  |
| Ажил эрхлэлт                      | 51.9 | 48.7 | 46.1 | 51.0 | 49.8 | 50.3 | 47.1 | 56.0 | 54.3 | 44.5 | 48.9 | 59.5 | 61.0 | 49.8 | 53.6 | 57.9 | 51.4 | 56.8 | 51.7 |          |                  |
| Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа | 43.0 | 32.5 | 40.4 | 25.5 | 17.8 | 42.8 | 36.9 | 41.9 | 48.6 | 47.7 | 48.3 | 48.2 | 46.4 | 39.3 | 36.4 | 48.4 | 48.3 | 44.6 | 49.0 |          |                  |
| Бараа материалын нөөц             | 39.4 | 49.2 | 47.8 | 33.6 | 32.5 | 46.8 | 39.3 | 39.5 | 51.2 | 54.3 | 54.8 | 53.8 | 60.8 | 53.8 | 52.7 | 61.9 | 50.5 | 57.6 | 44.2 |          |                  |

**Барилга:** Тайлант улиралд тус салбарын нийт үзүүлэлтүүдийн утга агших мужид гарчээ. Өмнөх улирлын утгатай харьцуулбал бараа материалын нөөцийн үзүүлэлт 12.0, ажил эрхлэлт 8.6, шинэ захиалга 5.0, үйлдвэрлэлийн үзүүлэлт 3.9, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт 1.2 нэгжээр тус тус буураад байна (Хүснэгт 2).

**Хүснэгт 2. Барилгын салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр**

| Үзүүлэлт                          | 2021 |      |      |      | 2022 |      |      |      | 2023 |      |      |      | 2024 |      |      |      | 2025 |      |      | Өөрчлөлт | Улирлын өөрчлөлт |
|-----------------------------------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|----------|------------------|
|                                   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  |          |                  |
| Барилга ерөнхий индекс            | 28.7 | 37.4 | 36.1 | 30.7 | 36.9 | 35.0 | 35.9 | 30.4 | 47.4 | 44.9 | 39.0 | 45.0 | 47.8 | 49.0 | 43.3 | 46.8 | 41.4 | 43.2 | 37.6 |          |                  |
| Шинэ захиалга                     | 24.2 | 41.2 | 42.6 | 31.2 | 35.7 | 30.4 | 31.4 | 22.9 | 39.3 | 45.5 | 36.7 | 36.2 | 42.2 | 42.9 | 41.7 | 47.5 | 37.5 | 35.6 | 30.6 |          |                  |
| Үйлдвэрлэл                        | 22.4 | 36.9 | 38.2 | 32.4 | 32.0 | 33.8 | 34.8 | 26.7 | 48.7 | 43.9 | 39.4 | 49.9 | 54.5 | 61.6 | 47.5 | 46.0 | 36.6 | 43.4 | 39.6 |          |                  |
| Ажил эрхлэлт                      | 41.1 | 46.2 | 41.7 | 36.4 | 45.6 | 37.0 | 36.5 | 29.7 | 53.2 | 41.5 | 28.7 | 47.2 | 48.2 | 49.1 | 43.2 | 43.9 | 47.3 | 47.3 | 38.7 |          |                  |
| Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа | 33.3 | 25.0 | 19.5 | 29.3 | 43.4 | 56.7 | 56.3 | 60.3 | 55.8 | 52.8 | 49.3 | 55.7 | 49.4 | 45.4 | 46.5 | 52.8 | 49.0 | 50.0 | 48.8 |          |                  |
| Бараа материалын нөөц             | 26.7 | 28.4 | 24.9 | 16.1 | 25.1 | 15.8 | 20.7 | 18.8 | 44.9 | 40.3 | 50.6 | 38.4 | 45.0 | 40.5 | 32.5 | 43.4 | 41.5 | 46.6 | 34.6 |          |                  |

**Дотоод худалдаа:** 2025 оны III улиралд ажил эрхлэлт, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт тэлэлтийн мужид гарсан бол бусад үзүүлэлтүүд агших мужид гарлаа. Өмнөх улирлын утгатай харьцуулахад ажил эрхлэлт 6.0, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 0.3 нэгжээр тус тус өссөн бол үйлдвэрлэл 8.1 нэгж, бараа материалын нөөц 6.7, шинэ захиалга 2.0 нэгжээр тус тус буурлаа (Хүснэгт 3).

**Хүснэгт 3. Дотоод худалдааны салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр**

| Үзүүлэлт                          | 2021 |      |      |      | 2022 |      |      |      | 2023 |      |      |      | 2024 |      |      |      | 2025 |      |      | Өөрчлөлт | Улирлын өөрчлөлт |
|-----------------------------------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|----------|------------------|
|                                   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  |          |                  |
| Дотоод худалдаа ерөнхий индекс    | 31.9 | 37.5 | 41.7 | 42.6 | 35.1 | 45.4 | 38.2 | 42.5 | 56.2 | 50.4 | 52.4 | 50.0 | 49.1 | 54.4 | 52.2 | 49.2 | 39.0 | 43.3 | 41.3 |          |                  |
| Шинэ захиалга                     | 21.7 | 34.8 | 41.7 | 41.4 | 39.2 | 45.1 | 34.1 | 39.9 | 57.3 | 50.9 | 54.5 | 48.8 | 48.0 | 56.2 | 53.5 | 50.8 | 29.9 | 36.8 | 34.8 |          |                  |
| Үйлдвэрлэл                        | 26.5 | 37.5 | 47.9 | 48.0 | 28.2 | 50.2 | 37.8 | 43.7 | 64.2 | 62.9 | 61.9 | 51.1 | 46.3 | 63.8 | 56.9 | 47.2 | 26.4 | 43.8 | 35.8 |          |                  |
| Ажил эрхлэлт                      | 45.4 | 44.0 | 49.4 | 51.2 | 50.7 | 48.2 | 44.2 | 42.1 | 54.8 | 43.6 | 46.2 | 52.2 | 51.5 | 51.5 | 51.6 | 49.2 | 49.6 | 44.3 | 50.3 |          |                  |
| Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа | 41.0 | 36.7 | 27.8 | 27.5 | 17.3 | 41.7 | 35.0 | 40.0 | 42.8 | 36.8 | 43.3 | 50.3 | 43.0 | 44.1 | 40.9 | 48.9 | 58.8 | 50.8 | 51.1 |          |                  |
| Бараа материалын нөөц             | 35.5 | 33.9 | 31.9 | 37.9 | 35.2 | 34.7 | 44.5 | 52.0 | 55.6 | 51.3 | 48.8 | 45.6 | 64.2 | 46.2 | 55.0 | 49.7 | 47.4 | 48.7 | 41.9 |          |                  |

**Үйлчилгээ:** Салбарын ерөнхий үзүүлэлтүүдийн хувьд үйлдвэрлэл (*бизнесийн идэвхжил*), нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт тэлэлтийн мужид шилжиж сайжирсан байна. Харин шинэ захиалга, ажил эрхлэлтийн үзүүлэлт сүүлийн 3 улирал дараалан агших мужид гарлаа. Өмнөх улирлын утгатай харьцуулахад үйлдвэрлэл 14.0, ажил эрхлэлт 10.3, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 2.3 нэгжээр тус тус өссөн бол шинэ захиалга 0.7 нэгжээр буурчээ (Хүснэгт 4).

#### Хүснэгт 4. Үйлчилгээний салбарын ерөнхий индекс, үзүүлэлтүүдээр


| Үзүүлэлт                          | 2021 |      |      |      | 2022 |      |      |      | 2023 |      |      |      | 2024 |      |      |      | 2025 |      |      | Өөрчлөлт | Улирлын өөрчлөлт |
|-----------------------------------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|------|----------|------------------|
|                                   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  | IV   | I    | II   | III  |          |                  |
| Үйлчилгээ ерөнхий индекс          | 28.9 | 39.0 | 40.7 | 40.4 | 39.1 | 50.5 | 46.4 | 46.9 | 50.5 | 53.6 | 53.1 | 57.4 | 54.5 | 55.2 | 53.3 | 52.6 | 45.8 | 40.3 | 46.8 |          |                  |
| Шинэ захиалга                     | 24.6 | 38.0 | 43.3 | 40.9 | 39.9 | 48.6 | 40.5 | 45.3 | 48.4 | 55.0 | 54.4 | 60.6 | 55.0 | 56.8 | 51.6 | 51.6 | 43.4 | 39.6 | 38.9 |          |                  |
| Үйлдвэрлэл                        | 22.7 | 39.2 | 44.9 | 45.4 | 43.8 | 52.4 | 48.9 | 45.1 | 54.2 | 59.0 | 61.1 | 60.1 | 59.5 | 63.2 | 60.6 | 60.3 | 41.7 | 36.0 | 50.1 |          |                  |
| Ажил эрхлэлт                      | 41.7 | 50.7 | 44.0 | 49.9 | 49.1 | 54.6 | 53.5 | 46.1 | 49.1 | 48.4 | 47.1 | 55.0 | 56.4 | 54.2 | 50.8 | 50.6 | 47.7 | 39.5 | 49.8 |          |                  |
| Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа | 30.4 | 25.5 | 25.2 | 19.8 | 17.5 | 45.6 | 44.4 | 53.5 | 50.2 | 49.0 | 45.9 | 50.2 | 43.4 | 40.7 | 48.1 | 45.0 | 54.4 | 49.7 | 52.4 |          |                  |

### 3. ААН-ийн хэмжээгээр PMI индекс

Аж ахуйн нэгжүүдийг жилийн борлуулалтын орлогын хэмжээгээр жижиг (1.0 тэрбум хүртэл ₮), дунд (1.0-2.5 тэрбум ₮), том (2.5-с дээш тэрбум ₮) гэж ангилан тайлант улирлын PMI индексийн утгыг тооцвол том ААН-үүдийн индексийн утга 3, дунд ААН-үүд 4, жижиг ААН-үүд 19 улирал дараалан агших мужид гараад байна. Индексийн утгыг өмнөх улиралтай харьцуулахад жижиг ААН-үүд 4.7, дунд ААН-үүд 9.2 нэгжээр тус тус буурч, харгалзан 36.7, 36.0 байв. Харин том ААН-үүд 1.2 нэгжээр өсөж 46.4 гарчээ (Зураг 5).

Зураг 5. PMI индекс, аж ахуйн нэгжийн хэмжээгээр

PMI, 50=өөрчлөлтгүй



**Жижиг:** ААН-үүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт 1.8 нэгжээр өсөж тэлэлтийн мужид гарсан бол бусад бүх үзүүлэлт агших мужид гарсан байна. Өмнөх улиралтай харьцуулахад ажил эрхлэлт 6.9, шинэ захиалга 6.4, үйлдвэрлэл 5.3, бараа материалын нөөц 3.7 нэгжээр тус тус буурч агших мужид хэвээр гарлаа.

**Дунд:** ААН-үүдийн хувьд энэ улиралд бүх үзүүлэлт агших мужид хэвээр хадгалагдсан байна. Өмнөх улирлын утгатай харьцуулахад бараа материалын нөөц 6.7, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны үзүүлэлт үйлдвэрлэл 3.8 нэгжээр өссөн бол үйлдвэрлэл 16.1, шинэ захиалга 15.5, ажил эрхлэлт 8.8 нэгжээр тус тус буурсан байна.

**Том:** ААН-үүдийн хувьд ажил эрхлэлт, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа тэлэлтийн мужид шилжсэн бол бараа материалын нөөц агших мужид гарлаа. Харин шинэ захиалга, үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд сүүлийн 3 улирал дараалан агших мужид хэвээр гарлаа. Өмнөх улирлын утгатай харьцуулахад үйлдвэрлэл 4.8, ажил эрхлэлт 3.7, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа 3.3 нэгжээр тус тус өссөн бол бараа материалын нөөц 12.2, шинэ захиалга 0.1 нэгжээр тус тус буурчээ (Хүснэгт 5).


### Хүснэгт 5. PMI индекс, аж ахуйн нэгжийн хэмжээ, үзүүлэлтүүдээр

| Үзүүлэлт                          | 2021        |             |             |             | 2022        |             |             |             | 2023        |             |             |             | 2024        |             |             |             | 2025        |             |             | Өөрчлөлт | Улирлын өөрчлөлт |
|-----------------------------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|----------|------------------|
|                                   | I           | II          | III         | IV          | I           | II          | III         | IV          | I           | II          | III         | IV          | I           | II          | III         | IV          | I           | II          | III         |          |                  |
| <b>Жижиг ААН</b>                  | <b>28.3</b> | <b>35.0</b> | <b>41.3</b> | <b>39.9</b> | <b>35.0</b> | <b>42.8</b> | <b>38.1</b> | <b>40.3</b> | <b>43.2</b> | <b>48.7</b> | <b>43.2</b> | <b>42.4</b> | <b>48.3</b> | <b>43.6</b> | <b>45.4</b> | <b>44.2</b> | <b>37.7</b> | <b>41.5</b> | <b>36.7</b> |          |                  |
| Шинэ захиалга                     | 18.6        | 32.1        | 43.9        | 37.7        | 33.4        | 42.6        | 36.7        | 35.0        | 39.6        | 50.2        | 39.9        | 39.6        | 48.6        | 44.2        | 43.3        | 38.9        | 33.1        | 37.3        | 30.8        |          |                  |
| Үйлдвэрлэл                        | 18.1        | 31.4        | 42.2        | 39.0        | 34.7        | 42.6        | 36.2        | 40.4        | 45.9        | 52.6        | 45.8        | 44.5        | 49.5        | 42.5        | 46.2        | 43.0        | 30.0        | 35.2        | 30.0        |          |                  |
| Ажил эрхлэлт                      | 40.8        | 38.2        | 39.1        | 45.3        | 43.7        | 42.5        | 39.9        | 40.9        | 38.6        | 40.7        | 35.0        | 39.9        | 44.2        | 43.2        | 44.7        | 45.3        | 35.9        | 43.3        | 36.4        |          |                  |
| Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа | 46.5        | 48.2        | 39.5        | 43.7        | 27.6        | 50.1        | 47.7        | 53.6        | 53.2        | 52.4        | 49.1        | 49.7        | 53.9        | 42.7        | 45.4        | 52.6        | 60.5        | 55.5        | 57.3        |          |                  |
| Бараа материалын нөөц             | 30.1        | 26.5        | 38.2        | 32.6        | 34.5        | 34.2        | 29.5        | 34.8        | 41.1        | 44.7        | 54.3        | 39.8        | 44.0        | 46.5        | 50.8        | 48.6        | 39.9        | 45.2        | 41.4        |          |                  |
| <b>Дунд ААН</b>                   | <b>38.2</b> | <b>38.9</b> | <b>44.3</b> | <b>42.4</b> | <b>33.5</b> | <b>38.6</b> | <b>39.9</b> | <b>43.5</b> | <b>46.9</b> | <b>46.6</b> | <b>48.4</b> | <b>49.6</b> | <b>46.3</b> | <b>45.7</b> | <b>55.1</b> | <b>43.7</b> | <b>44.3</b> | <b>45.2</b> | <b>36.0</b> |          |                  |
| Шинэ захиалга                     | 33.1        | 36.1        | 45.6        | 44.8        | 34.4        | 35.0        | 34.2        | 39.1        | 49.1        | 48.9        | 48.7        | 47.1        | 44.2        | 44.7        | 53.5        | 40.2        | 44.6        | 45.2        | 29.6        |          |                  |
| Үйлдвэрлэл                        | 32.1        | 42.2        | 51.5        | 43.7        | 28.3        | 37.0        | 45.1        | 45.1        | 47.4        | 50.6        | 52.2        | 54.4        | 45.8        | 49.2        | 59.8        | 46.2        | 41.6        | 48.6        | 32.5        |          |                  |
| Ажил эрхлэлт                      | 48.1        | 45.9        | 45.1        | 51.5        | 49.6        | 44.4        | 45.1        | 45.9        | 42.6        | 38.0        | 43.7        | 52.2        | 48.1        | 44.1        | 50.4        | 40.4        | 46.3        | 44.2        | 35.5        |          |                  |
| Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа | 38.2        | 33.8        | 32.0        | 28.1        | 24.0        | 46.6        | 39.8        | 53.0        | 49.8        | 54.1        | 51.9        | 45.1        | 49.7        | 46.2        | 53.8        | 46.6        | 52.1        | 43.2        | 47.0        |          |                  |
| Бараа материалын нөөц             | 49.1        | 32.8        | 38.8        | 34.9        | 26.0        | 30.0        | 33.4        | 33.3        | 43.6        | 35.8        | 41.6        | 47.1        | 45.6        | 42.6        | 59.1        | 50.5        | 35.2        | 42.0        | 48.7        |          |                  |
| <b>Том ААН</b>                    | <b>35.0</b> | <b>42.0</b> | <b>43.3</b> | <b>41.9</b> | <b>36.9</b> | <b>47.4</b> | <b>45.3</b> | <b>48.6</b> | <b>51.7</b> | <b>52.9</b> | <b>53.6</b> | <b>57.4</b> | <b>54.6</b> | <b>53.3</b> | <b>51.2</b> | <b>53.9</b> | <b>45.2</b> | <b>45.2</b> | <b>46.4</b> |          |                  |
| Шинэ захиалга                     | 30.4        | 41.9        | 46.4        | 47.2        | 38.3        | 46.2        | 45.4        | 48.6        | 49.6        | 54.8        | 56.3        | 59.8        | 54.0        | 52.5        | 49.7        | 51.7        | 40.3        | 41.3        | 41.2        |          |                  |
| Үйлдвэрлэл                        | 29.1        | 42.2        | 44.8        | 43.7        | 38.2        | 49.2        | 47.1        | 51.9        | 54.3        | 59.1        | 59.4        | 61.7        | 56.1        | 63.1        | 57.6        | 58.0        | 41.1        | 42.6        | 47.4        |          |                  |
| Ажил эрхлэлт                      | 47.0        | 49.9        | 46.1        | 50.3        | 49.8        | 52.1        | 49.6        | 49.7        | 53.6        | 46.6        | 47.7        | 57.2        | 58.3        | 52.6        | 52.5        | 54.5        | 50.3        | 47.7        | 51.4        |          |                  |
| Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа | 35.9        | 28.6        | 31.1        | 22.5        | 17.5        | 43.8        | 40.0        | 46.4        | 48.6        | 46.7        | 46.3        | 49.9        | 44.3        | 40.4        | 41.2        | 47.2        | 51.9        | 47.3        | 50.6        |          |                  |
| Бараа материалын нөөц             | 37.8        | 45.7        | 43.3        | 33.6        | 32.9        | 42.8        | 39.7        | 41.3        | 52.5        | 53.9        | 53.6        | 51.6        | 61.3        | 51.8        | 52.2        | 59.2        | 49.8        | 55.5        | 43.3        |          |                  |

## 4. Олон улсын PMI индекс

### Зураг 6. Худалдааны голлох түнш улсуудын PMI

PMI, 50=өөрчлөлтгүй



Эх сурвалж: S&P global, Монголбанк

**Худалдааны голлох түнш улсуудын PMI<sup>2</sup>:** 2025 оны III улиралд манай худалдааны голлох түнш улсуудын PMI индекс ОХУ-с бусад орнуудад тэлэлтийн мужид гарлаа. Тухайлбал, Евро бүсийн ерөнхий индексийн утга тэлэлтийн мужид 51.2 гарсан бөгөөд үйлдвэрлэл, шинэ захиалга 2024 оны 5 сараас хойших хамгийн хурдацтай өссөн. Харин түүхий эд, үйлдвэрлэлийн зардал буурчээ. БНХАУ-ын нийт бизнесийн идэвхжил нэмэгдэж 50.3 гарсан байна. Бизнесийн идэвхжил 11 сар дараалан өссөн ч аж үйлдвэр, үйлчилгээний салбарын аль алиных нь тэлэлт удааширч, хамгийн бага хурдацтай байлаа. Үүнд, шинэ захиалга 2022 оны 12 сараас хойш анх удаа буурсан нь голлох нөлөөг үзүүлжээ. ОХУ-ын бизнесийн идэвхжил сүүлийн 3 жилийн хугацааны хамгийн хурдацтай буурснаар 46.6 гарсан байна. Үүнд аж үйлдвэр, үйлчилгээний салбарын аль

<sup>2</sup> Голлох түнш улсуудын PMI индексийн тухайн улирлын сүүлийн сарын үзүүлэлтээр тооцсон болно.

алинд үйлдвэрлэл буурсан нь нөлөөлжээ. Шинэ захиалга, ажил эрхлэлт огцом буурч, түүхий эд, үйлдвэрлэлийн зардал өссөн байна. АНУ-ын PMI ерөнхий индекс 53.9 гарсан бөгөөд бизнесийн идэвхжил тогтвортой өсөлттэй байна. Харин шинэ захиалгын өсөлт саарч, үйлдвэрлэлийн зардлын өсөлт өндөр хэвээр байлаа. Дэлхийн PMI ерөнхий индекс 52.4 гарсан бөгөөд сүүлийн 3 жилийн туршид тэлэлтийн мужид байна. Үйлдвэрлэл, шинэ захиалга өсөлт саарч байгаа боловч ажил эрхлэлт тогтвортой байна.

## 5. ААН-ийн ерөнхий мэдээлэл

Судалгааны түүвэрлэлт хийхдээ аж үйлдвэр, барилга, дотоод худалдаа (бөөний болон жижиглэн) болон үйлчилгээний салбаруудаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй, эх олонлогийг төлөөлөхүйц 405 ААН-ийг *жижиг (1.0 тэрбум хүртэл ₮), дунд (1.0-2.5 тэрбум ₮), том (2.5-с дээш тэрбум ₮)* гэж ангилан түүвэрлэлт хийсэн бөгөөд ингэхдээ тухайн ангилалд хамаарах бүх аж ахуйн нэгжүүдээс жилийн борлуулалтын орлогоор тэргүүлэх аж ахуйн нэгжүүдийг түүвэрт сонголоо.

Судалгааны асуулгыг **2025 оны 10-р сард нийт 405** аж ахуйн нэгжийн дунд явуулсан бөгөөд *аж үйлдвэрийн салбарын 145, барилгын салбарын 72, дотоод худалдааны салбарын 69, үйлчилгээний салбарын 119* аж ахуйн нэгжүүд судалгаанд хамрагдлаа. Борлуулалтын орлогын хэмжээгээр жижиг ангилалд хамаарах 189 (47%), дунд 64 (16%), том 152 (38%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо (Хүснэгт 6).

**Хүснэгт 6. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, жилийн борлуулалтын орлогын бүлгээр<sup>3</sup>**

| Ерөнхий салбар   | Салбар                                              | ААН-ийн тоо 2025.III* | Жижиг | Дунд | Том | Нийт | Эзлэх хувь |
|------------------|-----------------------------------------------------|-----------------------|-------|------|-----|------|------------|
| Аж үйлдвэр (145) | Уул уурхай, олборлолт                               | 1,250                 | 2     | 1    | 7   | 10   | 2%         |
|                  | Боловсруулах үйлдвэрлэл                             | 7,825                 | 63    | 15   | 33  | 111  | 27%        |
|                  | Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 4,854                 | 13    | 2    | -   | 15   | 4%         |
|                  | Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж         | 298                   | 1     | 1    | 4   | 6    | 1%         |
|                  | Усан хангамж                                        | 261                   | 1     | 1    | 1   | 3    | 1%         |
| Барилга          | Барилга                                             | 8,963                 | 28    | 14   | 30  | 72   | 18%        |
| Дотоод худалдаа  | Бөөний болон жижиглэн худалдаа                      | 44,697                | 28    | 9    | 32  | 69   | 17%        |
| Үйлчилгээ (119)  | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа                   | 4,738                 | 4     | 2    | 5   | 11   | 3%         |
|                  | Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа | 3,438                 | 4     | 1    | 4   | 9    | 2%         |
|                  | Мэдээлэл, холбоо                                    | 3,305                 | 2     | 1    | 4   | 7    | 2%         |
|                  | Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа            | 2,055                 | 3     | 1    | 5   | 9    | 2%         |
|                  | Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа                   | 1,253                 | 2     | 1    | 2   | 5    | 1%         |
|                  | Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн ү.а       | 7,431                 | -     | -    | 1   | 1    | 0%         |
|                  | Боловсрол                                           | 3,912                 | 2     | 1    | 3   | 6    | 1%         |
|                  | Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа          | 2,968                 | 5     | 1    | 5   | 11   | 3%         |
|                  | Урлаг, үзвэр, тоглоом наадам                        | 1,217                 | -     | 1    | 1   | 2    | 0%         |
|                  | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа                    | 8,752                 | 31    | 12   | 15  | 58   | 14%        |
| Нийт             |                                                     | 107,217               | 189   | 64   | 152 | 405  | 100%       |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ажилтны тооны бүлгээр ангилан авч үзвэл 49 хүртэл ажилтантай 323 (80%), 50-199 хүртэл ажилтантай 60 (15%), 200-с дээш ажилтантай 22 (5%) аж ахуйн нэгж судалгаанд хамрагджээ (Хүснэгт 7).

<sup>3</sup> 2025 оны III улирлын байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн тоо

**Хүснэгт 7. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, ажилтны тооны бүлгээр**

| Ерөнхий салбар  | Ажилтны тоо   | Жижиг | Дунд | Том | Нийт | Эзлэх хувь |
|-----------------|---------------|-------|------|-----|------|------------|
| Аж үйлдвэр      | 1-49 хүртэл   | 80    | 18   | 22  | 120  | 30%        |
|                 | 50-200 хүртэл |       | 1    | 11  | 12   | 3%         |
|                 | 200-с дээш    |       | 1    | 12  | 13   | 3%         |
| Барилга         | 1-49 хүртэл   | 28    | 13   | 21  | 62   | 15%        |
|                 | 50-200 хүртэл |       | 1    | 9   | 10   | 2%         |
|                 | 200-с дээш    |       |      |     | -    | 0%         |
| Дотоод худалдаа | 1-49 хүртэл   | 28    | 9    | 19  | 56   | 14%        |
|                 | 50-200 хүртэл |       |      | 11  | 11   | 3%         |
|                 | 200-с дээш    |       |      | 2   | 2    | 0%         |
| Үйлчилгээ       | 1-49 хүртэл   | 53    | 19   | 13  | 85   | 21%        |
|                 | 50-200 хүртэл |       | 2    | 25  | 27   | 7%         |
|                 | 200-с дээш    |       |      | 7   | 7    | 2%         |
| Нийт            | 1-49 хүртэл   | 189   | 59   | 75  | 323  | 80%        |
|                 | 50-200 хүртэл | -     | 4    | 56  | 60   | 15%        |
|                 | 200-с дээш    | -     | 1    | 21  | 22   | 5%         |
| Нийт            |               | 189   | 64   | 152 | 405  | 100%       |

## Хавсралт. Худалдан авалтын менежерийн индексийн тухай

Худалдан авалтын менежерийн индекс (PMI) нь бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид болон аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудын хувьд эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг харах, үйл ажиллагаагаа удирдах, төлөвлөх, урьдчилан таамаглах, шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой үзүүлэлт болдог. PMI нь тооцоход хялбар энгийн аргачлал дээр үндэслэгдэж, албан ёсны статистик тоон мэдээлэл гарахаас өмнө эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг тодорхойлохын зэрэгцээ бусад орнуудтай харьцуулалт хийх боломж олгодгоороо давуу талтай. Олон улсын туршлагаас харахад уг индексийг тооцохдоо эдийн засгийн голлох салбаруудын нөлөө бүхий 400 орчим аж ахуйн нэгжүүдийг сонгон түүвэрлэлтэд хамруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, шинэ захиалга, ажил эрхлэлт, бараа материалын нөөц, хүргэлтийн хугацаа болон бусад үзүүлэлтийн талаарх мэдээллийг судалж, эдгээр үзүүлэлт бүрээр индексийн утгыг тооцон, индексийн өөрчлөлтийг харгалзан дүгнэлт өгдөг.

“Худалдан авалтын менежерийн индекс (Purchasing manager index-PMI)” нь эдийн засгийн ерөнхий хандлагыг харуулсан чиглэлийн индекс юм.

**Аргачлал:** Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс үзүүлэлт тус бүрийн хувьд өмнөх улирлаас хэрхэн өөрчлөгдсөн талаар чанарын асуулт асууж, хариултуудыг нэгтгэх замаар тоон буюу индексийн утгад шилжүүлнэ. Индексийг үзүүлэлт тус бүрээр тооцон гаргаж салбаруудын индекс, нийлмэл индекс, нийт эдийн засгийн индексийг тооцоолоход ашиглана.

**PMI (тухайн үзүүлэлтийн тархалтын индекс) =  $(K1 * 1) + (K2 * 0.5) + (K3 * 0)$**

$k1$  = Өссөн гэсэн хариултын хувь

$k2$  = Хэвэндээ гэсэн хариултын хувь

$k3$  = Буурсан гэсэн хариултын хувь

Уг индексийн тооцоолсон утгыг **тархалтын индекс** гэж нэрлэх бөгөөд PMI=50 бол бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүйг, PMI>50 бол бизнесийн үйл ажиллагааны тэлэлтийг, PMI<50 бол агшилтыг тус тус илэрхийлдэг. Энэхүү утга 50-аас холдох тусам тэлэлт эсвэл агшилт ихэснэ. Тодруулбал, PMI-ийн үзүүлэлт өмнөх улирлын үзүүлэлтээс өндөр байвал эдийн засаг илүү хурдтай тэлж (агшиж) байгааг, харин өмнөх улирлаас доогуур байвал илүү багаар тэлж (агшиж) байна гэсэн утгыг илэрхийлнэ.

